

УЛААНБААТАР ХОТЫН ТӨВИЙН ДҮҮРГҮҮДИЙН ОРЧИН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛИЙН ӨНДӨР НАСТАНД ЭЭЛТЭЙ БАЙДАЛ

*Н.Намсанцэцэг, М.Нарангэрэл, М.Энхбаяр, Г.Сэлэнгэ
О.Тогтохбаяр, Л.Гэрэлцэцэг Т.Дулмаа, Ч.Одгэрэл*

Геронтологийн үндэсний төв

Abstract: Environmental factors account for 15-20 percent of the that affecting human health. Thus, for making the social environment friendly to the elderly, it is necessary to develop intersectoral cooperation and create an environment that values the contribution of the elderly and provides them with the opportunity to participate in all aspects of social life. **Goal:** Evaluate the services and atmosphere in 6 areas of the heart of Ulaanbaatar that are friendly to the elderly. **Materials and method:** For this study, 5 elderly persons were randomly chosen from each of the 3 subdistricts that were randomly chosen from each of the 6 districts from the central area of Ulaanbaatar city. 50 questionnaires with groups were used to assess the family hospitals, communities, banks, stores, and supermarkets that they frequently visit, as well as their interior and external environments and services. **Result:** 51.9% of respondents claimed that green facilities outside community centers and family hospitals are typical, while 55.3% said that green facilities outside banks and shopping malls are inadequate. The condition of the environment and services provided by the institutions were rated as inadequate by 93.5% of survey respondents and adequate by 6.5%.

Keywords: age-friendly environment, services, external environment, internal environment, and attitudes

Үндэслэл

Манай улсад 2020 оны байдлаар 60 ба түүнээс дээш насны нийт хүн ам 7.3 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ тоо 2050 он гэхэд 18 хувьд хүрч 5 хүн тутмын нэг нь ахмад настан ангилалд багтах тооцоолол байна(Эрүүл мэндийн үзүүлэлт, 2020).

Хүний эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлсэд орчны нөлөө 15-20 хувийг эзэлдэг(ДЭМБ, Номхон далайн баруун бүсийн эрүүл насжилтын үйл ажиллагааны төлөвлөгөө, 2019). Эрүүл мэнд, нийгмийн болон орчны нөлөөллөөс хамаарч хүмүүсийн насжилт харилцан адилгүй явагддаг бөгөөд үүний улмаас настнуудын эрүүл мэнд, үйл ажиллагааны чадвар маш их ялгаатай байдаг (Department of Elderly Affairs, 2016).

Настнууд нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцоход ээлтэй орчин хангалттай сайн биш байгаагаас улбаалан нийгмээс тусгаарлагдах, ганцаардал, айдас, сэтгэл түгшил, сэтгэл гутралд орох нь элбэг, гэмтэл бэртэл авах эрсдэл их байгаагаас гадна тэдэнд хандах хандлага ч сөрөг байсаар байна.

Нас өндөр гарсан хойно эрүүл байх нь насан туршдаа хуримтлуулсан эрүүл зан үйл, орчны нөлөөллийн үр дүн юм (Department of Elderly Affairs, 2016). Иймээс нийгмийн орчныг настанд ээлтэй болгохын тулд салбар хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, настнуудын хувь нэмрийг үнэлдэг, нийгмийн бүхий л амьдралд оролцох боломжийг нь хангасан орчин бүрдүүлэх шаардлагатай юм.

Зорилго

Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн настанд ээлтэй гадаад, дотоод орчин, үйлчилгээг үнэлэх


Судалгааны арга, аргачлал:

Судалгаанд Улаанбаатар хотын төвийн 6 дүүргээс тус бүр 3 хороог зорилтот түүврийн аргаар сонгож дүүрэг тус бүрээс орон сууцны хороолол, гэр хороолол, орон сууц болон гэр хосолсон хороог тус тус хамруулсан. Сонгогдсон хороодоос тус бүр 5 ахмад настныг санамсаргүй байдлаар сонгож, тэдний голчлон үйлчлүүлдэг өрхийн эмнэлэг, хороо, банк болон дэлгүүр зах, супермаркетуудын гадаад дотоод орчин, үйлчилгээг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Монголын ахмадын холбооноос боловсруулан гаргасан Ахмад настанд ээлтэй байгууллага шалгаруулах 5 бүлэг бүхий 50 асуумжаар үнэлэв. Асуумж судалгаанд ерөнхий үнэлгээгээр 85-100 оноо авбал тухайн байгууллагын орчин болон үйлчилгээг хангалттай гэж үзнэ. Харин 85-аас доош оноо авбал хангалтгүй гэж үзэж, орчин үйлчилгээг сайжруулах санал зөвлөмж өгнө. Судалгаанд 6 дүүргийн нийт 490 үйлчилгээний байгууллага хамрагдсанаас судалгааны шаардлага хангасан 417

нэгж өгөгдөлд судалгааны үр дүнгийн мэдээллийн өгөгдлийг кодлох, шивэх, алдааг шалгасны дараа SPSS 26.0 программ ашиглан боловсруулалт хийв.


Судалгааны үр дүн

Үйлчилгээний байгууллагуудын гадаад болон дотоод орчныг үнэлэхэд гадаад орчин дахь машины зогсоолын хүрэлцээ 30 хүртэл хувь нь сайн, 42 орчим хувь нь гадна талбайд машины зогсоолгүй, зогсоол нь хүрэлцээгүй байдаг гэж үзсэн байна.




Зураг 1. Гадна талбай ногоон байгууламжтай байдал

Үйлчилгээний байгууллагуудын гадна орчин дахь ногоон байгууламжийн талаар үнэлж үзэхэд 20.7 хүртэлх хувь нь сайн, 51.9 хүртэлх хувь нь хэвийн, 55.3 хүртэлх хувь нь маш муу гэж үнэлэгдсэн. Мөн судалгаанд оролцогчдын 14-26 хүртэлх хувь нь өрхийн эмнэлэг, хороо болон банкны гадна талбайд амрах сандалтай, сандал нь хүрэлцээтэй гэсэн бол 37-54.7 хүртэлх хувь нь дэлгүүр захын гадна талд сандалгүй, хүртээмж муу гэж үнэлсэн нь гадна талбайд ногоон байгууламжийн тоо хэмжээг нэмэгдүүлэх, хүрэлцээтэй хэмжээний сандал болон амрах талбайг бий болгох шаардлагатайг харуулж байна. Байгууллагын гадна довжоо болон тэргэнцрийн налуу зам, бариул зэрэгт үнэлгээ хийхэд дунджаар 50 орчим хувь нь хангалтгүй муу, хэвийн гэж үзсэн 34 хувь, 15.9 хувь хангалттай гэж үнэлсэн байна.



Зураг 2. Хүлээлгийн танхим, хонгилд тухтай амрах сандалтай, хүрэлцээтэй

Байгууллагын дотоод орчинд үйлчлүүлэгчид болон настнууд суугаад хүлээх тав тухтай, сандлын хүртээмжийг үнэлэхэд банканд 58.8 хувь нь хангалттай гэж үзсэн бол хороонд 27.9 хувь нь байдаггүй гэж үнэлсэн байна. Настнууд болон үйлчлүүлэгчид тухайн байгууллагаас үйлчилгээ авахаар хүлээж байх үедээ ус цэвэршүүлэгчээс ус хийгээд уух боломж нөхцөл дээрх дөрвөн байгууллагад 56-73.5 хувь хүртэл бүрдээгүй үзүүлэлттэй байна.




Зураг 3. Ариун цэврийн өрөө нь настан зуурч босох бариултай байдал

Үйлчлүүлэгчдийн ариун цэврийн өрөөний хүрэлцээтэй байдал өрхийн эмнэлэгт 34.2 хувь, хороонд 41.3 хувьтай байгаа бол банк болон дэлгүүр захын 60-аас дээш хувь нь үйлчлүүлэгчдийн ариун цэврийн өрөөгүй байна. Ариун цэврийн өрөөний дунджаар 56.2 хувь нь өндөр настан зуурч босох бариулгүй байна.


Ажилтнуудын үйлчилгээний соёл, хандлагын хувьд өрхийн эмнэлэг болон банкнаас үйлчилгээ авахад дугаарлалт, хүлээгдэл их байдаг бол үйлчилгээний ажилтны ёс зүй, түргэн шуурхай үйлчлэх байдал, хувцаслалт сайн байна. Харин байгууллагын талаар санал гомдол гаргах хайрцаг, жижиг үсгээр бичигдсэн шошго унших томруулдаг шил 50-иас дээш хувь нь байршуулаагүй байна.

Үйлчилгээний байгууллагаар ахмад настнууд үйлчлүүлэхэд үл тоомсорлох, хайхрамжгүй хандах мэдрэмж 50-аас дээш хувьтай төрсөн байгаа нь ахмад настныг насаар ялгаварлах, хүндэтгэхгүй байх хандлага ажиглагдаж байна.



Зураг 4. Үйлчилгээ сэтгэлд хүрсэн байдал

Зураг 14-өөс үзэхэд дээрх 4 байгууллагын үйлчилгээг судалгаанд оролцогчдын 55-аас дээш хувь нь сэтгэлд хүрсэн үйлчилгээтэй гэж үзсэн байна.



Зураг 5. Ерөнхий үнэлгээ

Судалгаанд оролцогч настууд дээрх үйлчилгээний байгууллагуудын орчин болон үйлчилгээг 93.5 хувь нь хангалтгүй, 6.5 хувь нь хангалттай гэж үзсэн байна.

Дүгнэлт

1. Үйлчилгээний байгууллагын гадаад орчинд ногоон байгууламж болон машины зогсоол, ахмад настуудад амрах сандал амралтын талбайн хүрэлцээг нэмэгдүүлэх, цаашид баригдах үйлчилгээний байгууллагуудад энэхүү шаардлагыг тавих хэрэгцээтэй байна.
2. Байгууллагын болон нийтийн бие засах газарт үйлчлүүлэгч, настуудад зориулсан байнгын ажиллагаатай ариун цэврийн өрөөг бий болгох настанд ээлтэй байдлаар тохижуулах шаардлагатай байна.
3. Төрийн болон төрийн бус байгууллагууд ижил хэмжээнд настанд ээлтэй дотоод орчныг бий болгож хүлээлгийн сандал болон ус цэвэршүүлэх төхөөрөмжөөр хангах шаардлагатай байна.
4. Настанд ээлтэй гадаад болон дотоод орчин маш хангалтгүй үзүүлэлттэй гарсан бөгөөд үйлчилгээний байгууллагууд настанд ээлтэй орчныг бий болгон үйл ажиллагааг хэвшмэл болгох шаардлагатай байна.

Ашигласан материал

Эрүүл мэндийн үзүүлэлт. (2020).

Retrieved from <https://fliphtml5.com/zfecd/kdac/basic>

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. (2019). *Номхон далайн баруун бүсийн эрүүл насжилтын үйл ажиллагааны төлөвлөгөө*. Улаанбаатар: "Эм Жи Эл дизайн" ХХК.

Department of Elderly Affairs. (2016). Situation of the Thai Elderly.

Afacan, Y. (2013, March 01). Elderly-Friendly Inclusive Urban Environments: Learning from Ankara. 38, 52-62. doi:10.1108/OHI-01-2013-B0006

Department of Elderly Affairs. (2016). Situation of the Thai Elderly.

Somposon, W. (2022). Issues and Needs of Elderly in Community Facilities and Services: A case study of Urban Housing Projects in Bangkok, Thailand. doi:10.3390/su14148388

Ч.Одгэрэл (2022). *Улаанбаатар хотын ахмад настанд ээлтэй орчны үзүүлэлтүүд*. Улаанбаатар.

Khoddam, H. (2019). The age-friendly cities characteristics from the viewpoint of elderly. doi:10.4103/jfmpc.jfmpc_1098_20